



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №09


2019 оны 3-р сарын 18-22

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ


Улсын хэмжээнд 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт 55 яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 43(78.1) галзуугийн эрсдэлд өртсөн, 7(12.7%) хачигт халдвар, 2(3.6%) хумхаа, 1(1.8%) ям, 1(1.8%) денги, 1(1.8%) бэтэг өвчний сэжигтэй тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

1.1. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:

Булган, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хэнтий, Хөвсгөл, Завхан аймгийн 15 сум, нийслэлийн 3 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт 43 тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2%-иар их байна. Эпидемиологийн 11-р долоо хоногтой харьцуулахад 3 тохиолдлоор бага үзүүлэлттэй байна.




Галзуу өвчний сэжигтэй зэрлэг, мал амьтанд уруулж, ноцуулан, шүлсдүүлсэн хүмүүсийн тохиолдлыг эх уурхайгаар нь авч үзвэл: чононд (27.9%) эзэнтэй нохойд (27.9%), үнэгэнд (16.3%), эзэнгүй нохойд (16.3%), мануулд (7%), тэмээнд (2.3%) нь уруулсан байна.



Энэ долоо хоногт Өмнөговь аймгийн (Ханбогд, Даланзадгад), Хөвсгөл аймгийн (Мөрөн) сумаас галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол тус тус 1 бүртгэгдсэн. Эрсдэлд өртсөн тохиолдлууд эмнэлэгт хандаж шархны анхны цэгцлэлт, ариун боолт хийлгэж галзуугийн эсрэг вакцины эхний тун, ийлдэс эмчилгээнд хамрагдсан байна. Нохойг (эзэнтэй) уяж хяналтад авсан.

1.2 Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:

Баянхонгор, Булган, Дорнод, Говьсүмбэр аймгийн 4 сум, нийслэлийн 2 дүүрэгт хачгаар дамжих халдварын 7 сэжигтэй тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 41.7%-иар, эпидемиологийн 11-р долоо хоногтой харьцуулахад 1 тохиолдлоор тус тус буурсан үзүүлэлттэй байна.



Энэ долоо хоногт Дорнод аймгийн Хэрлэн сумаас хачигт энцефалитын 1 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн. 32 настай, эмэгтэй. 2019 оны 3-р сарын 01-нд хачигнд хазуулсан өгүүлэмжтэй. 3-р сарын 07-нд шилэн хүзүү дагзны орчим хавагнах шинж тэмдэг илэрч, 3-р сарын 14-нд аймгийн Нэгдсэн эмнэлэгт үзүүлсэн байна. ЗӨСҮТ-ийн лабораторийн шинжилгээгээр цусны ийлдсэнд хачигт энцефалит болон хачигт боррелиозын өвөрмөц эсрэгбие IgM илрээгүй байна.

1.3 Мэрэгч амьтны сэжигтэй дуудлага:

Он гарсаар нийт 6 удаагийн амьтны дуудлаганд үйлчилж, хураагдсан сорьц материалыг ЗӨСҮТ-ийн лабораторид шинжлэхэд тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчин үүсгэгч илрээгүй байна. **Энэ долоо хоногт** Нийслэлийн СХД-т 1 удаагийн амьтны (тарваганы муудсан арьс-1ш) дуудлагад үйлчилсэн. ЗӨСҮТ-ийн лабораторит хураагдсан сорьц материалд шинжилгээ хийгдэж байна.

Монгол улсад:

Галзуу өвчний мал, амьтны өвчлөл:

Увс аймгийн Зүүнхангай сумын Баянгол, Даланбулаг багт тус тус 1 үхэр 2-р сарын 27-ны өдөр галзуу өвчний шинж тэмдэгтэй хорогдсон тул дээж авч аймгийн МЭАЦЛ-д шинжлүүлэхэд галзуу өвчин болох нь тогтоогдсон. Тус суманд Сумын засаг даргын захирамжаар 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоон ажилласан байна.


Эх сурвалж: Увс ЗӨСТ

ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Олон улсад:


Эбола вируст халдвар:

2019 оны 3-р сарын 14-ний өдрийн ДЭМБ-ын мэдээлснээр Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад Эбола вируст халдварын сэжигтэй 927 тохиолдол (862 батлагдсан, 65 болзошгүй) бүртгэгдэж, үүнээс 584(63%) тохиолдол нас барсан тухай нийтэлсэн байна.



Зураг 1. Эбола вирус халдвар, Эпидемиологийн 7 хоноогоор

Нийт тохиолдлын 527(57%) нь эмэгтэйчүүд, 280(30%) нь 18-аас доош насны хүүхдүүд тус тус эзэлж байна. Тус улсад тандалт судалгаа үргэлжилж байна.



Зураг 1. Эбола вирус халдвар, Бүгд Найрмдах Ардчилсан Конго улс

Эх сурвалж: ДЭМБ


Африкийн гахайн мялзан өвчин:

Румын улсын Мал амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 3-р сарын 11-ний өдөр Калараси хотын гахайн аж ахуйд Африкийн гахайн мялзан өвчин бүртгэгдсэн тухай нийтэлжээ. Нийт 2 гахай өвчилж үхсэн байна.

Эх сурвалж: ДАЭМБ

Шувууны томуу өвчин:

2019 оны 3-р сарын 17-нд Балба улсын Хөдөө аж ахуйн яамнаас мэдээлснээр 2-р сарын 28-нд Катманду хотын Багмати нуурын ойролцоох шувууны аж ахуйд шувууны томуугийн H5N1 вирус халдварын дэгдэлт бүртгэгдэж, нийт 2600 шувуу өвчилж үхсэн ба 3252 шувууг устгасан тухай нийтэлжээ.



Эх сурвалж: ДАЭМБ

Африкийн гахайн мялзан өвчин:


Вьетнам улсын Мал амьтны эрүүл мэндийн газрын 2019 оны 3-р сарын 20-ны өдрийн мэдээгээр Лай Чао тосгонд 3-р сарын 18-нд Африкийн гахайн мялзан өвчин бүртгэгдсэн тухай нийтэлжээ. Нийт 117 гахайг устгасан байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Африкийн гахайн мялзан өвчин:

ОХУ-ын Хөдөө аж ахуйн яамны 2019 оны 3-р сарын 19-ний өдрийн мэдээгээр Калининград мужийн ойд 3-р сарын 17-нд Африкийн гахайн мялзан өвчин бүртгэгдэж, нийт 3 зэрлэг гахай өвчилж үхсэн тухай мэдээлжээ.



Эх сурвалж: ДАЭМБ

Африкийн гахайн мялзан өвчин:

Вьетнам улсын Мал амьтны эрүүл мэндийн газрын 2019 оны 3-р сарын 20-ны өдрийн мэдээгээр Лай Чао тосгонд 3-р сарын 18-нд Африкийн гахайн мялзан өвчин бүртгэгдсэн тухай нийтэлжээ. Нийт 117 гахайг устгасан байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Африкийн гахайн мялзан өвчин:

ОХУ-ын Хөдөө аж ахуйн яамны 2019 оны 3-р сарын 19-ний өдрийн мэдээгээр Калининград мужийн ойд 3-р сарын 17-нд Африкийн гахайн мялзан өвчин бүртгэгдэж, нийт 3 зэрлэг гахай өвчилж үхсэн тухай мэдээлжээ.



Эх сурвалж: ДАЭМБ

Энэ долоо хоногт үйл явдалд суурилсан тандалтын мэдээг Архангай(+), Баянхонгор(0), Багануур(0), Говь-Алтай(0), Завхан(0), Увс(+), Сэлэнгэ(0), Ховд(0), Өмнөговь(0), Дундговь(0), Хөвсгөл(0) аймгууд ирүүлсэн байна.